



VII/2022


Тархаасан: 2022 оны 8 дугаар сарын 12



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.0 хувиар өслөө

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 15.7 хувь, өмнөх оны эцсээс 10.6 хувь, өмнөх сараас 1.0 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 21.5 хувь (мах, махан бүтээгдэхүүн 3.0 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 29.4 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 9.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 13.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 17.9 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 18.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх оны эцсээс 10.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 5.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 8.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 10.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 13.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх сараас 1.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 1.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2022 оны 7 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2022 VII	2022 VII	2022 VII
		2021 VII	2021 XII	2022 VI
Ерөнхий индекс	100.0	115.7	110.6	101.0
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	121.5	116.9	101.4
Согтууруулах ундаа, тамхи	4.4	109.4	105.2	100.8
Хувцас, бөс бараа, гутал	16.6	113.8	108.0	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	111.3	110.1	100.4
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	116.6	111.3	101.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	117.9	113.9	101.2
Тээвэр	14.4	118.7	109.5	101.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	103.2	101.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	105.1	102.9	100.1
Боловсролын үйлчилгээ	4.8	103.4	100.1	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	115.6	107.7	100.6
Бусад бараа, үйлчилгээ	5.4	116.8	109.8	101.0

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 7 дугаар сард 7.7 хувь, 2020 оны 7 дугаар сард 3.4 хувь, 2021 оны 7 дугаар сард 7.4 хувь гарсан бол 2022 оны 7 дугаар сард 15.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 8.3 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 2. ИНФЛЯЦАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгжээр, жил бүрийн 7 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2019 VII	2020 VII	2021 VII	2022 VII
Ерөнхий индекс	7.7	3.4	7.4	15.7
Хүнсний бараа, ундаа, ус	2.5	2.0	3.2	6.3
Согтууруулах ундаа, тамхи	0.1	0.2	0.1	0.4
Хувцас, бөс бараа, гутал	1.5	0.7	0.6	2.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	1.2	0.2	0.5	1.1
Гэр ахуйн тавилга, бараа	0.2	0.2	0.3	0.8
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.3	0.1	0.2	0.7
Тээвэр	0.4	-0.9	1.7	2.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.0	0.0	0.0	0.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.5	0.0	0.1	0.2
Боловсролын үйлчилгээ	0.3	0.5	0.0	0.2
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.3	0.2	0.4	0.5
Бусад бараа, үйлчилгээ	0.3	0.2	0.3	0.9

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард улсын хэмжээнд 15.7 хувь гарсны 6.3 нэгж хувь буюу 40.1 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.


ХҮСНЭГТ 3. ИНФЛЯЦАД ИМПОРТЫН БАРААНЫ ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, жил бүрийн 7 дугаар сард, нэгж хувиар

Үзүүлэлт	2020 VII		2021 VII		2022 VII	
	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь
Ерөнхий индекс	3.4	100.0	7.4	100.0	15.7	100.0
Импортын барааны нөлөө	0.6	17.6	3.7	50.0	8.5	54.1

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлж байна.

Инфляц 2022 оны 7 дугаар сард 15.7 нэгж хувь гарсны 54.1 хувь буюу 8.5 нэгж хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 4.1 нэгж хувиар өсөж, өмнөх сараас 3.0 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар




Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2021 оны 7 дугаар сард 10.2 хувиар, 2022 оны 7 дугаар сард 20.0 хувиар өсөж, өсөлтийн хурдац 9.8 нэгж хувиар, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2021 оны 7 дугаар сард 6.0 хувиар, 2022 оны 7 дугаар сард 13.5 хувиар өсөж, өсөлтийн хурдац 7.5 нэгж хувиар тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 4. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 7 дугаар сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), бүлгээр, хувь

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	Ерөнхий индекс	107.4	107.9	107.7	105.7	107.5	106.6
2021 VII	Хүнс	110.2	109.8	112.9	109.3	110.2	111.6
	Хүнсний бус	106.0	106.8	105.8	104.2	106.2	104.3
	Ерөнхий индекс	115.7	115.9	114.1	114.5	116.9	115.2
2022 VII	Хүнс	120.0	120.0	117.0	121.2	121.2	119.7
	Хүнсний бус	113.5	113.7	113.0	111.7	114.9	113.1

2022 оны 7 дугаар сард хүнсний бүлгийн үнэ Хангайн болон Төвийн бүсэд өмнөх оны мөн үеэс 21.2 хувиар, хүнсний бус бүлгийн үнэ Төвийн бүсэд 14.9 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 3. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 7 дугаар сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувиар




Барааны бүлгийн үнэ 2021 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар, 2022 оны 7 дугаар сард 17.9 хувиар өсөж, өсөлтийн хурдац 9.1 нэгж хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 2021 оны 7 дугаар сард 3.1 хувиар, 2022 оны 7 дугаар сард 8.3 хувиар өсөж, өсөлтийн хурдац 5.2 нэгж хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 5. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 7 дугаар сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, бүсээр,

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
2021 VII	Ерөнхий индекс	107.4	107.9	107.7	105.7	107.5	106.6
	Бараа	108.8	109.6	109.0	106.3	108.7	107.3
	Үйлчилгээ	103.1	103.2	103.4	103.0	102.1	103.4
2022 VII	Ерөнхий индекс	115.7	115.9	114.1	114.5	116.9	115.2
	Бараа	117.9	118.0	116.5	116.9	119.4	117.6
	Үйлчилгээ	108.3	110.2	105.6	104.7	105.6	105.0

2022 оны 7 дугаар сард Төвийн бүсэд барааны бүлгийн үнэ 19.4 хувиар, Улаанбаатар хотод үйлчилгээний бүлгийн үнэ 10.2 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 4. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх сараас 1.7 хувиар буурахад хонь, ямааны мах 2.6 хувиар, үхрийн махны үнэ 2.3 хувиар буурсан, өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 2.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хот:


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2022 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.6 хувь, өмнөх оны эцсээс 10.9 хувь, өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 21.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 9.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 17.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 11.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 15.1 хувь, тээврийн бүлгийн үнэ 16.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх оны эцсээс 10.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 15.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 4.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 10.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 13.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 13.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 0.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.5 хувь, тээврийн бүлгийн үнэ 1.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС сараар (өмнөх оны мөн үеэс), хувиар




Улаанбаатар хотод 2022 оны 7 дугаар сард хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 32.0 хувь буюу 110 бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас өсөж, 7.2 хувь буюу 25 бараа, үйлчилгээний үнэ буурч, 60.8 хувь буюу 209 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байна. Энэ оны 6 дугаар сард судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн бараанаас 67 бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн бол 7 дугаар сард 52 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

ЗУРАГ 6. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЦУЛ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2022 оны 7 дугаар сард 16983 төгрөг болж, 2019 оны 7 дугаар сараас 16.3 хувь, 2020 оны 7 дугаар сараас 12.6 хувь, 2021 оны 7 дугаар сараас 2.7 хувиар өсөж, өмнөх сараас 2.3 хувь буюу 402 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 7. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 7 дугаар сард 15119 төгрөг болж, 2019 оны 7 дугаар сараас 23.1 хувь, 2020 оны 7 дугаар сараас 18.5 хувь, 2021 оны 7 дугаар сараас 2.2 хувиар өсөж, өмнөх сараас 1.7 хувь буюу 268 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 8. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 7 дугаар сард 12358 төгрөг болж, 2019 оны 7 дугаар сараас 23.1 хувь, 2020 оны 7 дугаар сараас 16.1 хувиар өсөж, 2021 оны 7 дугаар сараас 0.7 хувиар, өмнөх сараас 3.5 хувь буюу 445 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 9. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ НЭГ ЛИТР АИ-92 БЕНЗИНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2022 оны 7 дугаар сард 2389 төгрөг болж, 2019 оны 7 дугаар сараас 30.0 хувь, 2020 оны 7 дугаар сараас 71.1 хувь, 2021 оны 7 дугаар сараас 16.9 хувь тус тус өсөж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна.

Аймаг:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс бүх аймагт 13.3-18.0 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард Баян-Өлгий аймагт 13.3 хувиар өссөн нь хамгийн бага, Сэлэнгэ аймагт 18.0 хувиар өссөн нь хамгийн өндөр байна.


ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 7 дугаар сард (өмнөх оны мөн үеэс), хувь, аймаг, нийслэлээр



Аймгуудад худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 7 дугаар сард 10849 төгрөг болж, 2021 оны 7 дугаар сараас 115 төгрөгөөр буурсан байна.

Хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 7 дугаар сард Говьсүмбэр аймагт 9000 төгрөг байгаа нь хамгийн бага, Ховд аймагт 12742 төгрөг байгаа нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 11. АЙМГУУДАД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 7 дугаар сард, төгрөгөөр



Хэрэглээний бараа, үйлчилгээний 2015 оны суурийг 2020 оноор шинэчилж, туршилт тооцоог гаргалаа

"Хэрэглээний бараа, үйлчилгээний индекс тооцох аргачлал"-д бараа, үйлчилгээний үнийн суурийг 5 жил тутам шинэчлэхээр заасны дагуу ҮСХ-ноос 2015 оны сагс, жинг 2020 оноор шинэчлэж, туршилт тооцооллыг хийлээ.

Дэлхий даяар тархсан ковид19 цар тахлын нөлөө өрхийн хэрэглээ, зарлагад нөлөөлсөн тул 2020 оны хэрэглээний бараа, үйлчилгээний жинг Олон Улсын Валютын Сангаас ирүүлсэн зөвлөмж, бусад улс орны жишиг, туршлага зэргийг харгалзан өрхийн хэрэглээнд үндэслэн 2018-2020 оны дунджаар тооцооллоо.

Хэрэглээний бараа, үйлчилгээний 2020 оны жинг 2015 оныхтой харьцуулахад хувцас, бөс бараа, согтууруулах ундаа, тамхи, амралт чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ, хүнсний бараа, ундаа, ус, зочид буудал, нийтийн хоолны бүлгийн жин 0.1-4.3 нэгж хувиар буурч, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, тээвэр, холбооны хэрэгсэл, шуудан, орон сууц, ус, цахилгаан, гэр ахуйн тавилга, бараа, боловсролын үйлчилгээ, бусад бараа, үйлчилгээний бүлгийн жин 0.3-3.6 нэгж хувиар өслөө.

ХҮСНЭГТ 6. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИН, ӨӨРЧЛӨЛТ


Бүлэг	Жин		Өөрчлөлт, нэгж хувиар
	2015	2020	
Дүн	100.0	100.0	-
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	25.1	-1.0
Согтууруулах ундаа, тамхи	4.4	1.2	-3.2
Хувцас, бөс бараа, гутал	16.6	12.3	-4.3
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	9.3	10.3	1.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.9	5.4	0.5
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	7.2	3.6
Тээвэр	14.4	16.3	1.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	5.9	1.5
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	1.9	-1.2
Боловсролын үйлчилгээ	4.8	5.2	0.4
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	2.9	-0.1
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	-	0.5	-
Бусад бараа, үйлчилгээ	5.4	5.7	0.3

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг ҮСХ-ноос 2019 онд баталсан "Хувийн хэрэглээний зориулалттай бараа, үйлчилгээ"-ний ангиллын дагуу 13 бүлэг, 410 бараа, үйлчилгээг (Улаанбаатарт 398, аймагт 313 бараа, үйлчилгээ) хамруулан бүрдүүллээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний бүлэг "Даатгал, санхүүгийн үйлчилгээ" гэсэн 1 бүлгээр, сагсны бараа, үйлчилгээ улсын түвшинд 37, Улаанбаатарт 54, аймагт 75 бараа, үйлчилгээгээр тус тус нэмэгдсэн.

Шинэчилсэн сагс, жинд үндэслэсэн туршилтаар тооцоогоор хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ (2020=100%) 2022 оны 7 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 16.5 хувь, өмнөх оны эцсээс 11.0 хувь, өмнөх сараас 1.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 12. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 22.8 хувь (мах, махан бүтээгдэхүүн 3.6 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 25.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 18.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 15.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 14.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 21.6 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 15.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх оны эцсээс 11.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 17.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 11.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 11.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 14.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 7 дугаар сард өмнөх сараас 1.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 1.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 7. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2022 оны 7 дугаар сард, хувиар

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2022 VII 2021 VII	2022 VII 2021 XII	2022 VII 2022 VI
Ерөнхий индекс	100.0	116.5	111.0	101.1
Хүнсний бараа, ундаа, ус	25.1	122.8	117.7	101.7
Согтууруулах ундаа, тамхи	1.2	118.7	111.3	101.1
Хувцас, бөс бараа, гутал	12.3	115.4	111.0	100.7
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.3	114.5	111.5	100.7
Гэр ахуйн тавилга, бараа	5.4	115.2	109.6	101.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.3	121.6	114.8	100.4
Тээвэр	16.3	115.5	106.2	101.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	5.9	101.9	100.9	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	1.9	107.8	104.4	100.2
Боловсролын үйлчилгээ	5.2	104.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.9	117.2	110.1	100.4
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.5	110.9	103.6	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.7	117.6	110.4	101.4

Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

P_t^i - i барааны тайлант үеийн үнэ

P_o^i - i барааны суурь үеийн үнэ

Q_o^i - i барааны суурь үеийн жин

Хэрэглээний үнийн индексийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. Хэрэглээний үнийн индексийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна. Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.



Эх үүсвэр:

ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

Ангилал, код:

ХЗХБҮА

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 9 дүгээр сарын 12

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Д.Батсүх, Х.Хонгорзул
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212